

## **Солонгосын Төвбанкны ерөнхийлөгч Чонгсу Ким:**

### **Өрсөлдөх чадваргүй бол Монголын банкууд хаана ч хөлөө олохгүй**

БНСУ-ын Төвбангтай Монголбанк хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан билээ. Манай оронд богино хугацаанд айлчилж байгаа тус банкны тэргүүн Чонгсу Ким өчигдөр эх орныхоо эдийн засгийн амжилт хийгээд Монгол Улсад өгөх зөвлөмжийг багтаасан лекц уншсан юм.

### **Гадаад валютын нөөцийн хэмжээ чухал биш**

Энэ удаагийн лекцэнд Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж, Тамгын газрын захирал Г.Цэрэнпүрэв болон манай банк, санхүүгийн мэргэжилтнүүд оролцсон юм. Чонгсу Ким ерөнхийлөгчийн лекцийн эхлэл хэсэг нь бидний хамгийн их сонирхдог валютын нөөцийг тойрсон асуудал байв. “Энгийн иргэд валютын нөөц их байх тусмаа ашигтай гэж үздэг. Үнэндээ энэ ашиг тийм чухал биш. Алдагдалгүй байна гэдэг нь ашигтай байна гэсэн үг биш. Бид мэдээж хязгааргүйгээр валютыг нөөцөлж чадахгүйгээс хойш дэлхийн гол валютыг эзэмшиж байгаа улсуудтай валют солилцох гэрээ хийх хэрэгтэй” гэж тэрээр ярьсан.

### **Монголчуудад зориулсан хөгжлийн стратеги хэрэгтэй байна**

“Хамгийн гол нь Монгол Улс өрсөлдөх чадвар, сул талаа олж харах ёстой. Ингэж байж зөв стратегийг боловсруулна” гэж ноён Ким ярьсан. Түүнчлэн:

- Нийгмийн халамжийг эмзэг бүлгийнхэнд хүргэх
- Хувийн хэвшлийг дэмжиж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
- Төр, хувийн хэвшил хоёр хөрөнгө оруулах салбарын зааг, ангиллыг бий болгох
- Засгийн газар нь чадлаасаа хэтэрсэн хэрэглээг хязгаарлах

Зэрэг хөгжлийн түлхүүр болсон зөвлөгөөг өгсөн юм. Лекцийнх нь дараа ноён Кимээс зарим асуултад хариулт авлаа.

**-Хөгжлийн явцад Солонгосын банкуудын үүрэг ямар байсан бэ. Монголын хувьд одоо 14 банк байна. Гадаадын хөрөнгө оруулалттай зарим банк байгаа гэдэг ч үнэндээ гадаадын иргэд л оролцоотой байдаг учир бүгд дотоодын хөрөнгө оруулалттай гэж хэлж болохоор байна?**

-Солонгос улсад нээлттэй байх нь хамгийн чухал асуудал байлаа. Гэвч санхүүгийн нээлттэй байдал нь хамгийн хүнд хэцүү зам байсан. Засгийн газраас ямар ч тохиолдолд дотоодын банкаа гадаадынханд өгч болохгүй гэж үзэж байсан. Яагаад

гэвэл, маш эмзэг салбар. Би хувьдаа үүнээс эсрэг байсан ч Засгийн газрын даалгаврыг дагахаас аргагүй байсан. Гадаадын банкууд ч манай дотоодын банкуудын дутагдлыг маш их тайлбарладаг байсан. 1990 оны сүүл хүртэл гадаадын банкууд Солонгост төлөөлөгчийн газраа нээгээгүй. Гэвч 1997 онд хамгийн түрүүнд дампуурсан банк нь Солонгосын хамгийн том банк байсан юм. Үүнээс хойш Солонгосын банкуудын тодорхой хувийг гадаадууд эзэмших болсон. Одоо манай улсын хамгийн том банкны 70-80 хувийг гадаадынхан эзэмшиж байна. 1970-1980 онд банкууд маань маш их хохирч байсан. “Хьюндэй”, “Самсунг” зэрэг томоохон фирмийн салбарууд манай улсад нээлттэй байсан ч санхүүгийн салбар нь хаалттай байлаа. Өөрөөр хэлбэл, банкууд маань нээлттэй байгаагүй нь 1997 оны санхүүгийн хямралд маш их нөлөөлсөн.

**-Тэгвэл Монгол Улсын банк, санхүүгийн салбарыг Та хэрхэн харж байна. Бид цаашид явал хожлыг гартаа оруулах бол?**

-Төвбанк гэдэг улс оронд ганц л байдаг. Тиймээс Төвбанк нь гадаадын улс орнуудын Төвбангтай өрсөлдөхүйц хэмжээнд ажиллах ёстой. Монгол Улс нээлттэй банкны зарчмыг баримтлах нь зөв гэж үзэж байна. Өрсөлдөх чадварыг сайжруулахгүй бол Монголын банкууд хаана ч хөлөө олохгүй шүү дээ.

**-Манай Засгийн газрын зардал маш өндөр байгаа нь Монголбанкнаас явуулж байгаа инфляцийг тогтвортой төвшинд барих бодлоготой зөрж, улмаар иргэдийн нуруун дээр үнийн өсөлт дарамт болсоор байна. Солонгос улс 1960-1970 онд бас л хүнд даваатай тулсан. Туршлагаасаа бидэнтэй хуваалцаач?**

-Ерөнхийдөө Солонгос улсад 1970-1980 онд эдийн засгийн өсөлтийн бодлогыг голчилж байсан. 1960-1970 онд нэг хүнд ногдох ДНБ 100-200 ам.доллар байсан тул эдийн засгийн өсөлт хамгийн чухал нь байлаа. Бодлогын хосломол байдал нь төсөв, мөнгө, валютын ханш, хөдөлмөрийн зах зээл, татвар зэрэг бодлогоор хоорондоо уялдаатай байх ёстой. Сангийн яам, Төвбанк хоёр нь хоёр өөр тийшээ харж суугаад, аж үйлдвэр хариуцсан яам нь бас нэг ондоо тийшээ хандаад байвал тухайн улсын эдийн засаг хөгжихгүй. Бодлого нь хоорондоо уялдаатай байсан цагт ард түмэндээ хүрдэг.

**-Та Монголд нээлттэй бодлого хэрэгтэй байгаа талаар хэллээ. Чухам яаж санхүүгийн хувьд нээлттэй болох вэ?**

-Өнөөдөр Монгол Улсын Төвбанк зөв замаар ажиллаж байгааг хараад их таатай байна. Харин зах зээл нээлттэй байх хэрэгтэй. Яагаад гэвэл Монголын компаниуд дэлхийн зах зээл дээр өрсөлдөж байгаа учраас зах зээл нь ч бас нээлттэй байх учиртай. Эхний үед маш хэцүү байх нь тодорхой. Өрсөлдөх чадваргүй учраас тэр

шүү дээ. Өрсөлдөх чадвартай байхын тулд, нээлттэй болохын тулд болгоомжтойгоор эхлэх хэрэгтэй.

**Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж: Хүсэн хүлээсэн гадаадын банк орж ирэхгүй л байна**

Энэхүү уулзалт-лекцийн дараа Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржоос зарим асуултад хариулт авлаа.

**-Солонгосын Төвбанкны ерөнхийлөгч манай улсын санхүүгийн зах зээлийг нээлттэй байлгах тухай ярилаа. Харин энэ тухайд Монголбанкны ерөнхийлөгчийн хувьд юу гэж хэлэх вэ?**

-Монгол Улс үнэхээр хөгжье гэвэл өрсөлдөх чадвараа сайжруулах ёстой. Бид гадаадын банкуудад шалгуур тавьж байгаа. Тогтвортой хөгжлийг дэмжих 1-2 банкинд бид нээлттэй байгаа. Гэлээ ч бидний хүсэн хүлээсэн банк орж ирэхгүй л байна.